

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 2018/02

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлыг 2018 оны 4-р сарын 21-ний өдрийн 12.30 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Д.Нямбаяр 89172 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Л.Цэгмид 51830 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Л.Мягмаржав 3870 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Д.Сугаржав 1459 ширхэг хувьцааны саналаар /саналын хуудасаар/
Ч.Батмөнх 25964 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр Б.Анхбаяр/

172 295 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 58,2 хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Ч.Авдай, А.Төрсайхан болон ердийн гишүүн Л.Аззаяа нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л.Мягмаржав удирдав.

Хурлаар:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах асуудлыг тус тус хэлэлцэв.

Л.Мягмаржав: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б. Эрдэнэтуяа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 58,2% хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 12.40 минутанд эхлэв.

СОНССОН НЬ :

ТУЗ-ийн дарга Л. Мягмаржав: Бид Хөсөг Трейд компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцахын чацуу 2018 оны үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ. Ингээд та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Хуралд оролцогсдыг танилцуулав.

Компанийн үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр танилцуулав.

Компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодогч Б. Баасанжаргал танилцуулав.

Хуралд оролцогчдоос асуух зүйл байна уу.

- **Б.Анхбаяр** (Батмөнхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч): Газрын төлбөр дээр ердөө 11,500,000 төгрөг л төлсөн юм уу? Газрын төлбөр арай өндөр байсан шиг санагдахын?
- **Б.Баасанжаргал**: Газрын төлбөрийг хуримтлагдсан зардал дээр тусгагдсан байгаа.
- **Л.Мягмаржав**: Энэ тайланг харахад 278 сая төгрөгийн орлоготой, 261,0 сая төгрөгийн зарлага гарсан, зөрүү 17 сая төгрөг буюу цэвэр орлого, 131,0 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдал байгаан байна гэж ойлголоо. Ингээд бодохоор жилдээ 20 сая төгрөгийн ашигтай ажиллавал 5 жилийн дараа хуримтлагдсан алдагдлаа төлж дуусгана гэсэн үг байх нь.
- **Б.Анхбаяр** (Батмөнхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч): Газрын төлбөрт 27,183,600 сая хасуулаад 2017 онд 11 сая төгрөг төлсөн гэхээр нийт 38 сая төгрөг төлсөн юм байна тийм үү. Тайландаа орлогын бус зардлыг ямар санхүүгээр орж ирснийг задаргаатай нь бичвэл зүгээр байна.
- **Ч.Авдай**: Газрын төлбөр төлөгдөөгүй л яваад байсан юм уу?
- **Б.Баасанжаргал**: Анх манай газар хүлэмжийн зориулалттай гэж явж байсан юм байна лээ. Тухайн үедээ 200,000 орчмыг л төлөөд яваад байдаг байсан тэгсэн 2011 онд гэнэт тийм хуримтлагдсан өр, алданги орж ирсэн.
- **Б.Анхбаяр**: Одоо өглөг байгаа юу байна? Авлага юу байна?
- **Б.Баасанжаргал**: Өглөг 78,3 орчим сая, авлага байхгүй.
- **Б.Анхбаяр**: (Батмөнхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч): Нийт 210 сая орчим төгрөгийн орлого олж байж ноогдол ашиг олгох нээ. Энэ тайланд нийт манайхтай хамтран ажилладаг бүх байгууллагууд байгаа юу? Автотээврийн үндэсний төв жишээлбэл сарын хэдээр түрээсэлж байна.
- **Б.Баасанжаргал**: Автотээврийн үндэсний төв өвөлдөө 4,5 сая, зундаа 5,5 сая, Авто Гранд Мастер ХХК 3,5 сая, Контейнер байрлуулсны 500,000, Энх-Орчлонхүү авто сургууль 450,000, хамгийн өндөр нь Сүрэг хараацай 11 сая төгрөг, Буфет манайд засвар хийж орсон учир одоогоор түрээс авахгүй байгаа.
- **Л.Мягмаржав**: Сургуулиас түрээсийн мөнгө гэж авсан уу?
- **Б.Баасанжаргал**: 2016, 2017 оны түрээс гээд 10 сая төгрөг авсан.

- **Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр:** Сургуулийн хувьд гэрээжүүлэх үүднээс 2 удаа албан бичиг хүргүүлсэн байгаа.
- **Л.Мягмаржав:** Нийт хамтран ажиллаж байгаа байгууллагуудын хамтран ажиллах гэрээ хүчин төгөлдөр үү?
- **Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр:** Сургуулиас бусад нь бүгд хамтран ажиллах гэрээ нь хүчин төгөлдөр болсон. Сургуулийн хувьд гол мэддэг хүн нь гадаад байгаа учир хариу өгөхгүй байна.
- **Б.Баасанжаргал:** Түрээсийн бүх орлого зардал дансаар явагдаж байгаа.
- **Б.Анхбаяр** (Батмөнхийн итгэлмжлэгдсэн төлөөлөгч): Нягтлангаас асуухад нийт энэ өрийг хэзээ төлж дуусгана гэж бодож байна.
- **Б.Баасанжаргал:** Сардаа шахаад аль болох эрт төлж дуусгана гэж бодож байна.
- **Б.Анхбаяр** (Батмөнхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч): Жилдээ 17-20 сая төгрөгийн ашигтай ажиллаад 10 жилийн дараа дуусгана гэж ойлголоо.
- **Л.Мягмаржав:** Өөр асуух зүйл байна уу. За асуулт байхгүй бол ТУЗ-ын гаргасан тогтоолыг танилцуулья.

Ноогдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ын гаргасан Тогтоолыг ТУЗ-ын дарга Л. Мягмаржав уншиж танилцуулав.

- **А.Ариунсайн:** Ноогдол ашиг хувиарлах, хувиарлахгүй тухай шийдвэр гаргадаг эцсийн субъект нь ТУЗ байдаг. Компанийн тухай хуулийн 46.5 заасны дагуу эцсийн шийдвэрийг гаргадаг. ТУЗ уг шийдвэрийг хувьцаа эзэмшигчидийн хуралд мэдээлэх үүрэг хүлээдэг.

Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 15 цаг 30 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



/ Л.МЯГМАРЖАВ /

/ А.АРИУНСАЙН /